

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГАА-2026/014/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Алтай хот  
2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа  
Утас: 99998431 Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)  
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг  
Утас: 99175677 Цахим хаяг: [erdenechimegd@audit.gov.mn](mailto:erdenechimegd@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Б.Цэцэгмаа  
Утас: 99041524 Цахим хаяг: [Tsetsegmaab@audit.gov.mn](mailto:Tsetsegmaab@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091  
Утас: (976) 70 48 34 13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.03.24 № 137

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Тосгоны орон нутгийн төсвөөс Захирагчийн албанд 19.3 сая төгрөг төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон,
- Захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 6.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн,
- Усны төлбөрийн орлогын төлөвлөгөө 0.2 сая төгрөгөөр тасарсан байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 16 дугаар зүйлийн 16.5.2, 41 дүгээр зүйлийн 41.2.1 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн

822505000417

тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд тосгоны төсөвт байгууллагууд нэгдсэн дулааны шугамд холбогдон Хурд хүч чадал ХХК дулаан түгээж байна.

Цогт сумын Орон нутгийн хөгжлийн сангаас тосгоны "Гудамжны гэрэлтүүлэг"-ийг 19.5 сая төгрөг, "Хогийн толгойн хогийг булш тэгшлэх ажил"-д 19.0 сая төгрөг, "Цэцэрлэгт хүрээлэнг хашаажуулах"-д 19.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Тайлант онд 2 хөтөлбөр, 7 зорилт, 78 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, Цогт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 94.0 хувьтай үнэлсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамны [www.finperform.gov.mn](http://www.finperform.gov.mn) шинэчилсэн системээр нэгтгэсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Г.ГҮНЖИДМАА

## Хоёр.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны нэр, төрөл		Өмнөх он	Тайлант он
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	79,961.04	113,897.89
1.1.1	МӨНГӨН ХӨРӨНГӨ	41,299.87	80,481.19
1.1.3	АВЛАГА	17,520.46	7,488.59
1.1.5	БАРАА МАТЕРИАЛ	21,140.70	15,928.10
1.2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	899,184.52	863,495.01
1.2.2	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	899,184.52	863,495.01
1.2.2.02	Биет хөрөнгө	884,288.52	848,599.01
1.2.2.03	Биет бус хөрөнгө	14,896.00	14,896.00
1	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	979,145.56	977,392.89
2.1	НИЙТ ӨР ТӨЛБӨР	96.31	99,847.16
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	96.31	99,847.16
2.1.1.03	Өглөг	96.31	99,847.16
2.2	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	979,049.25	877,545.73
2.2.1	Засгийн газрын хувь оролцоо	979,049.25	877,545.73
2.2.1.01	Засгийн газрын оруулсан капитал	44,632.98	44,632.98
2.2.1.08	Хуримтлагдсан үр дүн	704,004.34	602,500.82
2.2.1.09	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	230,411.94	230,411.94
2	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	979,145.56	977,392.89

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,202,546.99	716,074.37
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	254,089.61	289,255.17
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар	252,024.82	288,055.75
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	254,997	291,068.39
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(2,972.18)	(3,012.64)
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	1,614.78	1,199.42
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	450	0.0
8	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	504,286.88	426,819.2
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	384,661.2
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	444,170.5	0.0
11	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	757,427.84	817,577.89
12	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	757,427.84	817,577.89
13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	754,937.84	816,877.89
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	175,250.32	184,223.82
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,480.02	23,892.89
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	430,470.88	467,394.18

17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	34,493.12	28,257.55
18	1.1.2.01.1.05 Нормативт зардал	360	0.0
19	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	17,456.6	10,350.2
20	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	986	1,540
21	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,014.1	1,049.74
22	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	72,426.8	100,169.52
23	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,490	700
24	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	445,119.15	-101,503.52
25	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	445,119.15	-101,503.52

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	533,930.1		533,930.1
2	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	533,930.1		533,930.1
3	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	445,119.15		445,119.15
4	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	979,049.25		979,049.25
5	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	979,049.25		979,049.25
6	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	979,049.25		979,049.25
7	1.7 Тайлант үеийн үр дүн	(101,503.52)		(101,503.52)
8	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	877,545.73		877,545.73

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	699,946.61	678,394.37
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	254,089.61	289,255.17
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	252,024.82	288,055.75
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(2,972.18)	(3,012.64)
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	1,614.78	1,199.42

6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	450.0	0.0
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	250.0	0.0
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	200.0	0.0
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,686.5	389,139.2
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	1,686.5	4,478
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	384,661.2
12	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	444,170.5	0.0
13	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	701,183.34	619,213.05
14	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	701,183.34	619,213.05
15	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	698,693.34	618,513.05
16	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	176,088.75	184,320.12
17	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,250.8	23,861.02
18	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	425,741.38	368,785.82
19	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	34,442.12	21,854.15
20	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	360	0.0
21	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	17,456.6	16,155.2
22	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	986	1,200
23	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,502.69	989.74
24	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	2,865	1,347
25	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,490	700
26	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(1,236.73)	59,181.32
27	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	8,893.0	20,000.0
28	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,893.0	20,000.0
29	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	8,893.0	20,000.0
30	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(8,893.0)	(20,000.0)
31	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(10,129.73)	39,181.32
32	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	51,429.6	41,299.87
33	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	41,299.87	80,481.19

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**(мянган төгрөг)**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	671,826.70	673,394.37
1	Урьд оны үлдэгдлээс	30,000.00	0.0
11	Татварын орлого	262,165.50	289,255.17
110	Орлогын албан татвар	261,256.10	288,055.75
1100	Хувь хүний орлогын албан татвар	265,120.10	291,068.39
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	254,992.50	272,541.75
110002	Үйл ажиллагааны орлого	1,160.90	1,668.90
110003	Хөрөнгийн орлого	6,433.20	16,271.83
110008	Шууд бус орлого	2,533.50	585.91
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(3,864.00)	(3,012.64)
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(3,864.00)	(3,012.64)
113	Хөрөнгийн албан татвар	709.40	1,199.42
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	709.40	1,109.42
113002	Бууны албан татвар	-	90.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	200.00	-
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	200.00	-
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	200.00	-
12	Татварын бус орлого	379,661.20	384,139.20
120	Нийтлэг татварын бус орлого	-	4,478.00
120003	Торгуулийн орлого	-	4,478.00
122	Тусламжийн орлого	379,661.20	379,661.20
122003	Аймаг нийслэлээс авсан татаас	379,661.20	379,661.20
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	671,826.70	634,213.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	671,826.70	634,213.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	664,146.70	633,513.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	192,615.90	184,320.12
210101	Үндсэн цалин	135,540.80	122,404.88
210102	Нэмэгдэл	45,520.10	53,497.86
210104	Урамшуулал	11,555.00	8,417.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,178.60	23,861.02
210201	Тэтгэврийн даатгал	16,076.30	16,076.30
210202	Тэтгэмжийн даатгал	2,275.60	2,180.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,137.80	1,097.17
210204	Ажилгүйдлийн даатгал	1,137.80	897.96
210205	Эрүүл мэндийн даатгал	4,551.10	3,609.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	371,396.00	368,785.82

Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	16,760.00	15,572.62
210302	Түлш, халаалт	354,636.00	353,213.20
2104	Хангамж, бараа материалын зардал	27,154.20	21,854.15
210401	Бичиг хэрэг	600.00	749.45
210402	Тээвэр, шатахуун	24,600.00	19,115.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	600.00	550.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	514.20	396.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	840.00	1,043.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,500.00	16,155.20
210604	Урсгал засвар	17,500.00	16,155.20
2107	Томилолт, зочны зардал	1,200.00	1,200.00
210702	Дотоод албан томилолт	1,200.00	1,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,695.00	15,989.74
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,500.00	15,924.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125.00	-
210807	Газрын төлбөр	70.00	65.74
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,407.00	1,347.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,407.00	1,347.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,680.00	700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,680.00	700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,680.00	700.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		41,299.87
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		80,481.19

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**(мянган төгрөг)**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000.0
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,000.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,000.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000.0
210602	Тавилга	5,000.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-

## **Гурав. Аудитын илрүүлэлт:**

**3.1** Аудитаар нийт 60.5 сая төгрөгийн дараах 2 алдаа илрүүлснийг аудитын явцад залруулсан байна.

### **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:**

- Байгууллагад өгөх өглөгийг 31.1 сая төгрөгөөр дутуу тусгасан.
- Хөрөнгийн дахин үнэлгээний хорогдлыг 29.4 сая төгрөгөөр бусад ангилалд бүртгэснийг тус тус залруулсан.

Аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт 26.1 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын төвшнөөс их бөгөөд харьяа байгууллагуудын материаллаг зөрчил 6.3 сая төгрөг байгаа тул шинж чанарыг харгалзан үзэж “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 26.1 сая төгрөгийн 4 зөрчил илрүүлснээс, 6.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага 19.8 сая төгрөгийн зөрчилд үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах 3 зөвлөмж өгсөн.

### **3.1.1 Харьяа байгууллагууд**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 1 төсвийн байгууллага, 4 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал, 1 төрийн сангийн санхүүгийн тайлан нэгтгэснээс 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 сан, 1 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Аудитаар Цогт сумын Баянтоорой тосгоны Цэцэрлэг, Сургууль, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

### **3.1.2 Түүвэрт хамрагдсан тосгоны Захирагчийн албаны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил**

Аудитаар шилэн дансны цахим системд мэдээлбэл зохих 128.8 сая төгрөгийн 29 мэдээллийг нөхөн мэдээлүүлэн залруулж, 6.3 сая төгрөгийн үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах 4 зөвлөмж хүргүүлсэн байна.

## **3.2 Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 26.1 сая төгрөгийн 4 зөрчил илрүүлснээс, 6.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 заалт албан шаардлага 19.8 сая төгрөгийн зөрчилд үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах 3 зөвлөмж хүргүүлж байна.

### **3.3 Албан шаардлага**

1.Тосгоны захирагчийн албаны 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 6.3 сая төгрөгийн 2 зөвлөмжийг хүргүүлсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

### 3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### Нэг. Төсвийн зохион байгуулалттай холбоотой

1. Тосгоны Соёлын төв "Хурд хүч чадал" ХХК-д түлш халаалтын зардлаас 6.6 сая төгрөг шилжүүлсэн боловч дулаанаар хангах гэрээ байгуулаагүй, халаалтын талбай, үнэ тодорхойгүй байхад хяналт хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай гэрээ байгуулахад хяналт хэрэгжүүлж халаалтын улирал бүр дүгнүүлэн, үр дүнг шийдвэрлэж ажиллах.

2. Усны төлбөрийн орлогын төлөвлөгөө 0.2 сая төгрөгөөр тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Цогт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 15 дугаар тогтоолыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орлогын төлөвлөгөөг бодитой үндэслэлтэй төлөвлөж гүйцэтгэлийг ханган ажиллах.

3. Тосгоны захирагчийн албанд 19.3 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"; гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харьяа байгууллагад олгох санхүүжилтийн хуваарийг батлан мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагч	3	782,492.0	1	722,057.3	2	60,434.7	3	782,492.0	-	-	-	-
Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн алба	1	128,846.6	1	128,846.6	-	-	1	128,846.6	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>911,338.6</b>	<b>2</b>	<b>850,903.9-</b>	<b>2</b>	<b>60,434.7</b>	<b>4</b>	<b>911,338.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Бүгд	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзах	Түүвэрт	Нийт зөрчил		Үүнээс									
							Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагч	1	-	1	-	-	-	5	26,122.5	-	-	3	19,472.5	2	6,650.0	-	-	-	-
Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн алба	1	-	-	-	-	1	2	6,334.9	-	-	-	-	2	6,334.9	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>7</b>	<b>32,457.4</b>			<b>3</b>	<b>19,472.5</b>	<b>4</b>	<b>112,203.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	1	-	-	-	1	-	-
2	Төсвийн шууд захирагч	1	-	1	-	-	-	-	-
	<b>НИЙТ</b>	2	<b>1</b>	<b>1</b>	-	-	<b>1</b>	-	-